



Монгол Улсын Их сургууль
Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль

“Resilience in Public Administration”

Гүйцэтгэсэн : Б.Цагаанцоож
Х.Энхзаяа

2019-11-29



Агуулга

2

- Үндэслэл
- Resilience гэж юу вэ?
- Resilience сэтгэл зүйн шинжлэх ухаанд
- Resilience тайлбарлах нь
- Resilience in Public Administration тухай ойлголт
- Төрийн алба ба төрийн албан хаагчийн тухай
- Resilience ба Мэдлэгийн менежмент
- Дүгнэлт
- Ашигласан материал



Үндэслэл

3

- Ямарваа нэгэн зүйлийн нэршил гэдэг бол зөвхөн хоосон оноолт биш харин түүний цаана тодорхой түүх, утга учир ойлголтууд агуулагдаж байдаг.
- Цаг хугацааны эргүүлэгт олон зүйл өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаагийн нэг жишээ бол бидний өдөр тутмын албан ажил, амьдралдаа хэрэглэдэг нэр томъёоны шинэтгэл юм.
- Нэр томъёо нь баяжин хөгжих явцад нэгэн зүйлийн нэр томъёог хууль тогтоомж, ном хэвлэлд янз янзаар хэрэглэх, нэг үзэгдлийг олон янз нэрлэх, шинээр нэвтэрч буй нэр томъёог өөр, өөр утгатай үзэгдэлд хэрэглэх явдал ажиглагдаж байна.



Resilience гэж юу вэ?

- **Resilience/нэр үг/:** уян, уян хатан байдал, уян хатан чанар
- **Resilient/тэмдэг нэр/:** сэтгэлийн хаттай, тэвчээртэй, хатуужилтай гэсэн утгыг илэрхийлдэг.
- “Resilience” хэмээх нэр томьёо нь сүүлийн 10 жилийн хугацаанд иргэний нөхцөл байдал, хямрал буюу гамшгийн менежменттэй холбоотой олон улсын байгууллага, эрдэм шинжилгээний ажлын гол нэр томьёо болж хувирсан байна.



Уян хатан чанар, уян хатан байдал гэж юу?

5

Уян хатан

А. Төмөр зэрэг хатуу зүйлийн нугарч хугарах чанар;

Б. Хүний хэрэг явдалд хүлээцтэй, наанатай цаанатай хандах чанар гэж үзсэн байдаг бөгөөд уян хатан байдал нь дасан зохицох чанартай холбогддог байна.



Resilience сэтгэл зүйн шинжлэх ухаанд

6

- **Resilience:** Хүн аливаа сэтгэлийн хямрал, өвчин эмгэг, золгүй явдал зэрэг өөрт тохиолдож буй өөрчлөлтүүдэд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх, тэдгээр хүчин зүйлүүдийг хэрхэн шийдвэрлэж, бэрхшээлийг төвөггүй даван гарч буйг Resilience буюу асуудалд бууж өгөх бус уян хатан байдлаар хандаж буйгаар тайлбарладаг.



Resilience сэтгэл зүйн шинжлэх ухаанд

- Харин эсрэгээрээ хувь хүн, бүлэг, улс төр, нийгэм зэрэг бүхий л түвшинд тулгарч буй асуудлыг шийдэж чадахгүй байх, өөрчлөлтөнд бэлэн бус байх үзэгдлийг **Fragility буюу хэврэг байдал** гэсэн үгээр тодорхойлж болох юм.



Уян хатан хүн ба уян хатан байгууллага

8

Уян хатан хүн:

- Өөрчлөлтөнд бэлэн байх чадвар,
- Дасан зохицох чадвар,
- Ирээдүйд тохиолдож болох аюул заналхийллийг урьдчилан харж, сэргийлэх арга хэмжээ авч чаддаг
- Шаардлагатай нөөцийг бүрдүүлж, хэрэгтэй үед ашиглаж чаддаг гэх мэт чадваруудыг агуулдаг байна.

Уян хатан байгууллага:

- Үр ашиггүй байдалтай хатуу тэмцдэг, ажилчдаа хөдөлмөрийн таатай нөхцлөөр хангасан,
- Үр дүн, гүйцэтгэлд суурилан ажилчдын хөдөлмөрийг үнэлдэг,
- Ажилтан албан хаагч нь мэргэшсэн байх ба тасралтгүй сайжрах үйл явцын хүрээнд дэвшин ажиллах боломжоор хангагддаг
- Үр ашигт суурилсан хэвтээ бүтэц бүхий байхыг дэмждэг.



“Resilience” тайлбарлах нь:

Resilience нь:

- Өөрчлөлтөнд бэлэн байх,
- Дасан зохицох, тасралтгүй сайжруулалт,
- Орчноо соргоогоор мэдэрч хурдтайгаар шинэчлэлт хийх чадвар,
- Нэгээс нөгөө рүү хөрвөх чадвартай байх,
- Баригдмал бус үргэлж өсөлт рүү тэмүүлдэг,
- Үр дүнд чиглэсэн тэнцвэртэй байдлыг илэрхийлдэг байна.
- Мөн түүнчлэн аливаа байгууллага уян хатан буюу хэвтээ бүтцээр үйл ажиллагаагаа явуулснаар ажилчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжид эерэгээр нөлөөлдөг.



“Resilience in Public Administration” гэж юу вэ?

10

- Уян хатан төрийн захиргаа/удирдлага/ эсвэл аливаа өөрчлөлт, хямрал/гамшиг/ зэрэг хүчин зүйлүүдэд уян хатан байдлаар ханддаг “тогтвортой төрийн захиргаа, удирдлага” гэх үү? Тогтвортой төр гэж юу вэ?



Тогтвортой төр гэж юу вэ?

11

Монгол хэлний их тайлбар толь:

- Юмны хөдлөхгүй байх бололцоо: **тогтвор сайтай** (эд зүйл тулгуур суурь сайтай),
- Төлөв томоо: **тогтвор суух** (буурь суух, томоожих, төлөв томоотой болох), **тогтвор суурьшил**(нэг газар удаан ажиллаж амьдрах), **тогтвор суурьшилтай ажиллах** (нэг газраа удаан ажиллах) гэж тайлбарласан байдаг.
- Уян хатан байдал нь аливаад залруулга хийж, өөрчлөх боломж олгодог бол тогтвортой байдал нь хатуу тогтоогдсон байдгаараа ялгаатай юм.
- Иимд Resilience in Public Administration гэдгийг Тогтвортой Төрийн Захиргаа хэмээх нь оновчгүй юм.



Resilience in Public Administration

12

- “Тэсвэртэй” хэмээх үгийн язгуур тэсвэр нь зовлон бэрхшээлийг тэсэж давах чадвар, хүлцэл, хатуужил, үйл хэрэг, санасан зорьсондоо хүрэх хичээл зүтгэл, хүнд бэрхийг даван туулах бие болоод сэтгэлийн хат, хүний зовлон бэрхшээл, элдэв зүйлийг хүлцэн дааж өнгөрүүлэх чадвар зэрэг утгыг агуулдаг.
- Харин хөрвөх чадвар нь нэгээс нөгөөрүү шилжих, өөрчлөлтөд хурдан дасан зохицох чадвар юм.

Эх сурвалж: Монгол хэлний их тайлбар толь



Тэсвэртэй, хөрвөх чадвартай төрийн захиргаа/удирдлага/ гэдгийг юу гэж ойлгох вэ?

13

- Шинэ зууны төрийн удирдлага нь мэдлэг, түншлэл, оролцоо, сүлжээ, мэдээллийн технологийн хөгжилд тулгуурлан хөгжиж байна.
- 21-р зууныг мэдээлэл технологийн эрин зуунд төрийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн технологийн хувьсгал маш хүчтэй нөлөөлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх арга замуудыг бий болгох шаардлагатай тулгарч байна.



Resilience in Public Administration

14

- Техник технологийн асар хурдацтай хөгжлийн эрин зуун болон бусад хүчин зүйлсээс үүдэн гарах эерэг болон сөрөг/гамшиг/ өөрчлөлтүүдэд хувь хүн болон төрийн байгууллага нь тэсвэртэйгээр дасан зохицож, уян хатан байдлаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөл бий болж байна.



Resilience in Public Administration

15

- Үүнээс гадна судлаачдын үзэж буйгаар 2050 он гэхэд дэлхийн хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдрах төлөвтэй байна.
- Соёлын олон янз байдал, техник технологитой холбоотойгоор нэмэгдэж буй хотжилт, төвлөрөл хүн амын хурдацтай өсөлт нь төрийн алба, жишээлбэл, хууль сахиулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хог хаягдлын менежмент зэрэг хотын дэд бүтцэд нөлөөлж, төрийн үйлчилгээг удаашруулж, тогтвортой байдлыг бууруулж болзошгүй юм



Resilience in Public Administration

16

- Эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтворгүй, хямралтай үед төрийн байгууллага нь эрсдлийг урьдчилан тооцоолох, болзошгүй аюул тохиолдоход түүнд бэлэн байх чадварыг тэсвэртэй байдал гэж ойлгож болно.



Resilience in Public Administration

17

- Хүчтэй, тэсвэртэй, хөрвөх чадвартай, уян хатан төрийн байгууллагын гол хөдөлгөгч хүч нь **төрийн албан хаагч** билээ.
- Төрийн албаны эрхэм зорилго нь “Иргэдэд ойрхон, уян хатан, идэвхтэй, санаачлагатай, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн”-д оршино. Өөрөөр хэлбэл: Төрийн захиргааны хөгжлийн бодлого нь: “Иргэдэд ойр, уян хатан” үйл ажиллагаа явуулах юм.



Resilience in Public Administration

18

- Төрийн албан хаагчийн мэргэжил, ур чадвар, сонгон шалгаруулалтын талаар хүний нөөцийн уян хатан орчин нөхцөл бий болсоор байгаа бөгөөд дээрээс доошоо шатлан захирах бюрократ бүтцийн албан тушаалын зэрэг дэвээс татгалзаж, удирдах албан тушаалтнуудыг авч ажиллуулахдаа уян хатан хандлага руу олон улсын чиг хандлага өөрчлөгдөж байна.



Resilience in Public Administration

19

- Мэдлэг чадвартай, мэргэшсэн “Чадварлаг” төрийн албан хаагчидтай байж хэмээн төрийн албаны үйл ажиллагаа иргэдэд үр ашигтай хүрнэ.
- Улсын салбарын шинэ менежмент нь **төрийн албыг илүү уян хатан, үр ашигтай болгох, төрийн албанд өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх, түүнд тохирсон урамшуулал олгох, зэрэг шинэтгэлийг санал болгосон.**



Төрийн албан хаагч ба Төрийн албаны тухай хууль

20

- Төрийн албаны тухай хууль нь төрийн албан хаагчийн ажлын баталгаа болж байгаа билээ.





Төрийн албан хаагч ба Төрийн албаны тухай хууль

21

“Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга”

3.1.3. “чадахуйн зарчим (мерит)” гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ **хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг хэлнэ**” гэж заасан

Гуравдугаар зүйлийн 23.2.3-т “ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд наймаас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд дөрвөөс доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх” гэж заасан.



Resilience in Public Administration

22

- “Resilience in Public Administration”-ны хүрээнд өнөөдөр улс орон бүр, цаашлаад дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлал боловсруулан хөгжлийн бодлогоо тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа нь хүн төрөлхтний амьдралын сайн сайхан байдлыг хангах, баталгаажуулах, хүмүүсийн хоорондын хүнлэг энэрэнгүй харилцааг бэхжүүлэх, хүрээлэн байгаа байгаль орчноо хамгаалахад чиглэгдэж байгаа юм.





Дүгнэлт

23

- Хувь хүн, бүлэг, нийгэм, улс төр, олон улсын харилцаа зэрэг бүхий л түвшинд тохиолдож болзошгүй эрсдэлт нөхцөлд төрийн алба нь үйл ажиллагааны зогсонги байдалд орохгүй тогтвортой үйл ажиллагаа явуулах чадвартай байх, гадаад болон дотоод хямрал/эдийн засаг, улс төр, нийгэм/, өөрчлөлтөд тэсвэртэй, хөрвөх чадвартайгаар даван туулах нь “Resilience in Public Administration” хэмээгчийг бүрэн илэрхийлнэ.
- Үүнд төрийн албан хаагчийн мэдлэг чадвар чухал нөлөөтэй байна. Ямар ч эрсдэлт нөхцөл байдал үүссэн түүнийг даван гарах арга зам нь ард иргэдийн болон төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар билээ.



Дүгнэлт

24

- Улс хөгжин дэвжихийн үндэс суурь нь төрд ажиллаж буй албан хаагчийн мэдлэг, ур чадвар юм.
- “Хүн мэдлэггүй байна гэдэг үнэнийг мэдээгүйтэй адил бөгөөд нийгмийн үнэнийг мэдээгүй хүн амьдраагүйтэй адил”.



Ашигласан материал

25

- Монгол хэлний их тайлбар толь
- Ш. Цогтоо Нийтийн захиргааны удирдлага, захиргааны эрх зүйн тусгай анги, УБ 2011
- ШУТИС, Төрийн удирдлага, УБ 2019
- Ш. Батсүх “Төрийн захиргаа засаглал”, УБ, 2017
- Төрийн албаны тухай хууль, 2017
- <https://dnn.mn/>



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

